

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Боловсролын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/45/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх
	аудитор: Ц.Наранчимэг
	Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
	Аудитын менежер: С.Нацагдорж
	Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
	Ахлах аудитор: Б.Батхишиг
	Утас: 261628 Цахим хаяг: batkhisigb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн	
Захирал: О.Бурмаа	
Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
МУБИС	Монгол Улсын боловсролын их сургууль
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026. 03.16 № 06/672
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангаас 230.4 сая төгрөгийн санхүүжилт авч, Алслагдсан орон нутгийн багш сурагчдын англи хэлний ур чадварыг дэмжих, Цэцэрлэгийн хүүхдийн хамгааллын бодлогын төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Боловсролын их сургууль нь Капитал банкинд 2017 оны 9 дүгээр сард 2,000.0 сая төгрөгийн хадгаламж байршуулсан боловч Монголбанкнаас 2019 онд тус банкны үйл ажиллагааг зогсоож, эрх хүлээн авагчийг томилсон байна. Капитал банкны эрх хүлээн авагч болон тус банкинд өр төлбөртэй Ви Эйч Энд Би ХХК-тай 3 талт эвлэрлийн гэрээ байгуулж, 2027 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд сургуулийн авлагыг барагдуулахаар тохирсон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 9 зорилгын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 98.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 343 дугаар тогтоолын дагуу 1,638.1 сая төгрөгийн 915 нэр төрлийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,912,675,730.42	39,579,732,458.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,091,175,111.97	31,615,328,744.98
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	12,091,175,111.97	11,252,493,128.54
31210	Төгрөг	11,332,128,043.92	10,828,094,099.77
31213	Арилжааны банк дахь харилцах	11,332,128,043.92	10,828,094,099.77
31220	Гадаад валют	759,047,068.05	424,399,028.77
31223	Арилжааны банк дахь харилцах	759,047,068.05	424,399,028.77
31500	Хадгаламж	15,000,000,000.00	20,362,835,616.44
33	АВЛАГА	7,403,905,768.77	7,648,977,228.07
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	15,599,292.31	4,931,719.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,298,493,035.08	5,556,101,186.08
33500	Бусад авлага	2,089,813,441.38	2,087,944,322.99
33510	Байгууллагаас авах авлага	2,080,648,706.87	2,077,361,232.48
33520	Хувь хүмүүсээс авах авлага	9,164,734.51	10,583,090.51
34	УРЬДЧИЛГАА	29,279,504.00	87,927,400.00
34600	Урьдчилж гарсан зардал	25,566,000.00	76,200,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	3,713,504.00	11,727,400.00
34714	Томилолтын урьдчилгаа	3,713,504.00	11,727,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	388,315,345.68	227,499,085.00
35100	Түүхий эд материал	1,151,268.68	-
35110	Тусгай зориулалттай материал	210,000.00	-
35130	Эм боох материал	941,268.68	-
35400	Хангамжийн материал	387,164,077.00	227,499,085.00
35410	Бичиг хэргийн материал	60,853,645.00	61,329,900.00
35420	Аж ахуйн материал	241,939,910.00	116,250,185.00
35430	Сэлбэг хэрэгсэл	836,800.00	-
35440	Түлш, шатах тослох материал	2,000,000.00	-
35450	Барилгын засварын материал	15,290,100.00	-
35470	Бусад хангамжийн материал	66,243,622.00	49,919,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	64,259,771,614.09	62,585,904,580.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	64,259,771,614.09	62,585,904,580.99
39200	Биет хөрөнгө	61,376,239,126.25	59,756,202,234.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	63,076,492,080.06	66,585,117,897.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,121,164,339.37)	(13,189,513,095.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	227,890,224.36	302,390,224.36
39204	Хуримтлагдсан элэгдэл	(189,952,453.16)	(211,327,724.60)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	11,590,421,721.18	12,144,678,634.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,444,963,455.57)	(8,970,121,251.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,418,389,773.06	6,342,844,528.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,976,418,668.58)	(4,885,654,882.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	974,317,522.86	780,553,361.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	(516,042,253.10)	(436,422,096.59)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	2,850,338,977.20	-
39217	Ном	1,486,929,997.31	1,293,656,638.27
39300	Биет бус хөрөнгө	2,883,532,487.84	2,829,702,346.30
39301	Програм хангамж	1,818,935,424.63	1,793,104,224.63
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,716,111,438.09)	(1,744,110,379.63)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,780,708,501.30	2,780,708,501.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	99,172,447,344.51	102,165,637,039.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,102,013,573.10	10,971,265,190.03
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,102,013,573.10	10,971,265,190.03
41300	Өглөг	378,498,898.28	135,675,760.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,181.00	713,886.60

Монгол Улсын Боловсролын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	42,807,600.00	42,807,600.00
41360	Бусад өглөг	335,681,117.28	92,154,274.20
41361	Байгууллагад төлөх өглөг	335,638,500.40	92,130,951.20
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	42,616.88	23,323.00
41400	Урьдчилж орсон орлого	12,723,514,674.82	10,835,589,429.23
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	452,324,817.21	733,939,012.10
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	12,271,189,857.61	10,100,705,817.13
41440	Бусад урьдчилж орсон орлого		944,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	86,070,433,771.41	91,194,371,849.01
51	Засгийн газрын хувь оролцоо	86,070,433,771.41	91,194,371,849.01
51100	Засгийн газрын оруулсан капитал	15,156,755,119.81	15,156,755,119.81
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	15,156,755,119.81	15,156,755,119.81
51200	Хуримтлагдсан үр дүн	37,196,226,101.73	42,321,711,420.25
51210	Өмнөх үеийн үр дүн	38,008,803,251.23	36,716,430,034.43
51220	Тайлант үеийн үр дүн	(812,577,149.50)	5,605,281,385.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,717,452,549.87	33,715,905,308.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	99,172,447,344.51	102,165,637,039.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	45,834,475,076.35	57,003,168,718.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,820,671,834.55	44,249,632,571.79
120	Нийтлэг татварын бус орлого	44,820,671,834.55	44,249,632,571.79
120002	Хүүгийн орлого	1,768,003,965.07	3,174,998,648.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,257,829,164.04	38,637,434,299.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,970,458,418.04	38,491,482,440.56
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,097,635,200.00	71,741,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	189,735,546.00	74,210,859.00
120005	Түрээсийн орлого	59,566,075.00	50,099,400.00
120009	Бусад орлого	543,063,720.44	2,176,005,359.05
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	172,708,910.00	203,443,188.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,500,000.00	7,651,676.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,013,803,241.80	12,753,536,146.59
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,013,803,241.80	12,753,536,146.59
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	249,641,540.00	12,110,372,746.59
131007	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	764,161,701.80	643,163,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	46,619,129,856.52	51,162,713,032.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,530,160,145.52	51,162,713,032.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,891,945,743.02	50,458,646,509.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,148,983,829.62	31,933,511,195.35
210101	Үндсэн цалин	28,148,983,829.62	31,933,511,195.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,472,659,812.15	3,918,199,618.82
210201	Тэтгэврийн даатгал	2,387,985,574.64	2,694,523,452.91
210202	Тэтгэмжийн даатгал	278,139,299.18	317,154,516.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	142,198,921.86	168,048,959.00
210204	Ажилгүйдлийн даатгал	130,396,360.34	135,720,433.35
210205	Эрүүл мэндийн даатгал	533,939,656.13	602,752,256.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,499,170,067.91	2,440,272,321.87
210301	Гэрэл, цахилгаан	640,266,361.78	851,223,200.39
210302	Түлш, халаалт	1,466,558,237.56	1,183,160,226.48
210303	Цэвэр, бохир ус	392,345,468.57	405,888,895.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,249,506,299.39	1,814,711,567.53
210401	Бичиг хэрэг	165,428,816.50	197,924,819.00
210402	Тээвэр, шатахуун	16,992,307.00	19,636,129.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	188,371,653.89	214,970,824.53
210404	Ном, хэвлэл	40,496,998.00	75,528,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	109,738,127.00	124,194,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	728,478,397.00	1,037,260,448.00
210408	Бараа материал акталсны зардал	-	145,196,807.00

Монгол Улсын Боловсролын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2105	Нормативт зардал	164,887,430.60	172,375,677.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,170,824.00	9,057,460.68
210502	Хоол, хүнс	123,235,606.60	141,484,116.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,481,000.00	21,834,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,321,291,871.00	1,124,173,425.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,802,615.00	23,766,523.00
210602	Тавилга	1,600,280.00	4,760,500.00
210604	Урсгал засвар	1,314,888,976.00	1,095,646,402.00
2107	Томилолт, зочны зардал	531,134,496.20	539,546,043.50
210701	Гадаад албан томилолт	420,920,162.20	410,438,142.50
210702	Дотоод албан томилолт	88,576,414.00	108,911,160.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	21,637,920.00	20,196,741.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,315,345,731.34	1,274,889,387.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,276,035,748.55	1,236,814,238.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	32,000,000.00	35,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	187,300.00	829,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	588,188.00	726,536.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,500.00	178,500.00
210807	Газрын төлбөр	6,265,354.00	1,068,270.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	125,640.79	272,343.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,188,966,204.81	7,240,967,272.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,340,233,535.63	1,353,426,540.43
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,893,349,770.46	2,053,922,795.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,955,382,898.72	3,833,617,936.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	638,214,402.50	704,066,523.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	638,214,402.50	704,066,523.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	638,214,402.50	704,066,523.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	88,969,711.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	88,969,711.00	-
221001	Их засвар	88,969,711.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(784,654,780.17)	5,840,455,685.66
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	189,320,995.05	712,848,311.72
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	7,920,165.92	38,279,153.71
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	181,400,829.13	674,569,158.01
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	217,243,364.38	948,022,611.56
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	(206,502,246.13)	(945,882,208.14)
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(10,741,118.25)	(2,140,403.42)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(812,577,149.50)	5,605,281,385.82

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,156,755,119.81	33,758,212,852.87	39,995,466,330.25	88,910,434,302.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,986,663,079.02)	(1,986,663,079.02)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,156,755,119.81	33,758,212,852.87	38,008,803,251.23	86,923,771,223.91
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	(40,760,303.00)	-	(40,760,303.00)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(812,577,149.50)	(812,577,149.50)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,156,755,119.81	33,717,452,549.87	37,196,226,101.73	86,070,433,771.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(479,796,067.30)	(479,796,067.30)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,156,755,119.81	33,717,452,549.87	36,716,430,034.43	85,590,637,704.11
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,547,240.92)	-	(1,547,240.92)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	5,605,281,385.82	5,605,281,385.82
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,156,755,119.81	33,715,905,308.95	42,321,711,420.25	91,194,371,849.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	48,015,616,188.48	54,041,639,500.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,934,602,908.68	41,288,103,354.37
120	Нийтлэг татварын бус орлого	38,934,602,908.68	41,288,103,354.37
120002	Хүүгийн орлого	1,768,003,965.07	3,174,998,648.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,592,695,423.40	35,866,986,297.45
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,436,017,873.40	35,441,034,438.45
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,097,635,200.00	351,741,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	59,042,350.00	74,210,859.00
120005	Түрээсийн орлого	47,003,821.00	59,396,400.00
120009	Бусад орлого	526,899,699.21	2,186,722,007.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,081,013,279.80	12,753,536,146.59
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,081,013,279.80	12,753,536,146.59
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	8,316,851,578.00	12,110,372,746.59
131007	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	764,161,701.80	643,163,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,650,895,110.21	47,316,813,427.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,650,895,110.21	47,316,813,427.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,012,680,707.71	46,613,506,904.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,175,521,395.91	31,627,416,698.07
210101	Үндсэн цалин	28,175,521,395.91	31,627,416,698.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,472,189,562.17	4,022,773,842.05
210201	Тэтгэврийн даатгал	2,387,515,324.66	2,824,066,086.14
210202	Тэтгэмжийн даатгал	278,139,299.18	311,057,679.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	142,198,921.86	164,909,223.00
210204	Ажилгүйдлийн даатгал	130,396,360.34	132,983,068.35
210205	Эрүүл мэндийн даатгал	533,939,656.13	589,757,784.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,773,700,190.13	2,440,272,321.87
210301	Гэрэл, цахилгаан	640,266,361.78	851,223,200.39
210302	Түлш, халаалт	1,741,088,359.78	1,183,160,226.48
210303	Цэвэр, бохир ус	392,345,468.57	405,888,895.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,318,090,275.89	1,634,486,119.53
210401	Бичиг хэрэг	168,532,445.00	179,911,030.00
210402	Тээвэр, шатахуун	18,775,028.00	17,775,811.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	188,371,653.89	214,970,824.53
210404	Ном, хэвлэл	51,536,998.00	77,491,690.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	109,738,127.00	120,429,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	781,136,024.00	1,023,907,414.00
2105	Нормативт зардал	167,339,047.60	174,718,908.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,977,660.00	8,116,192.00
210502	Хоол, хүнс	116,634,787.60	141,484,116.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,726,600.00	25,118,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,373,559,384.00	1,264,203,322.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,515,239.00	56,714,569.00
210602	Тавилга	1,600,280.00	
210604	Урсгал засвар	1,361,443,865.00	1,207,488,753.20

Монгол Улсын Боловсролын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	521,714,988.20	558,619,691.50
210701	Гадаад албан томилолт	408,000,654.20	429,767,790.50
210702	Дотоод албан томилолт	88,576,414.00	108,911,160.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	25,137,920.00	19,940,741.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,188,283,633.34	1,284,036,387.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,148,973,650.55	1,245,961,238.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	32,000,000.00	35,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	187,300.00	829,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	588,188.00	726,536.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,500.00	178,500.00
210807	Газрын төлбөр	6,265,354.00	1,068,270.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	125,640.79	272,343.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,022,282,230.47	3,606,979,612.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,159,695,833.01	1,505,401,122.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,862,586,397.46	2,101,578,490.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	638,214,402.50	703,306,523.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	638,214,402.50	703,306,523.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	638,214,402.50	703,306,523.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,364,721,078.27	6,724,826,073.52
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,187,561,415.60	(2,236,811,190.80)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,187,561,415.60	2,236,811,190.80
2200	Дотоод эх үүсвэрээр	2,187,561,415.60	2,236,811,190.80
221001	Их засвар	117,067,585.60	32,879,592.00
222001	Тоног төхөөрөмж	23,384,445.00	17,999,299.00
22301	Бусад үндсэн хөрөнгө		3,115,035.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,047,109,385.00	2,182,817,264.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,187,561,415.60)	(2,236,811,190.80)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(2,820,952.33)	36,138,750.29
14	Бусад эх үүсвэр	7,920,165.92	38,279,153.71
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	7,920,165.92	38,279,153.71
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	10,741,118.25	2,140,403.42
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	10,741,118.25	2,140,403.42
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,174,338,710.34	4,524,153,633.01
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,916,836,401.63	27,091,175,111.97
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,091,175,111.97	31,615,328,744.98

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйц	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			48,015,616.1	52,283,502.3	54,041,639.5	3,765,090.5	107.8	1,758,137.2	103.4
1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	м.төг	34,436,017.9	43,994,309.3	35,441,034.4	1,005,016.5	102.9	(8,553,274.9)	80.6
	Үүнээс: Бакалавр	м.төг		32,587,149.7	22,363,876.8				
	Магистр	м.төг		898,607.0	1,086,978.0				
	Доктор	м.төг		245,255.3	382,500.0				
	Гадаад оюутан	м.төг		1,490,309.7	1,475,396.8				
	Оюутны байр	м.төг		3,158,987.6	3,747,194.4				
	ЕБС сургалтын орлого	м.төг		4,616,000.0	4,714,726.8				
	ЭШ, менежмент болон нэмэлт орлого	м.төг		998,000.0	1,670,361.6				
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	м.төг	2,097,635.2		351,741.1	(1,745,894.1)	16.8	351,741.1	
Гадны төслийн орлого	м.төг	59,042.3		74,210.9	15,168.6	125.7	74,210.9		
Багш хөгжлийн төвийн сургалтын орлого	м.төг	526,899.7		2,186,722.0	2,186,722.0		2,186,722.0		
Хүүгийн орлого	м.төг	1,768,003.9	2,000,000.0	3,174,998.6	1,406,994.8	179.6	1,174,998.6	159.7	
Түрээсийн орлого	м.төг	47,003.8	92,827.0	59,396.4	59,396.4		(33,430.6)	63.9	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	м.төг		2,563,021.5				(2,563,021.5)		
Улсын төвлөрсөн төсвөөс	м.төг	2,861,796.9	3,633,344.5	12,753,536.1	9,891,739.2	445.6	9,120,191.6	351.0	
ЕБС хувьсах зардлын орлого	м.төг		700,000.0	643,163.4			(56,836.6)	91.8	
Тогтмол зардлын орлого	м.төг		2,933,344.5				(2,933,344.5)		
Боловсрол зээлийн сан	м.төг			12,110,372.7	12,110,372.7		12,110,372.7		
2 Нийт орлого	м.төг	48,015,616.1	52,283,502.3	54,041,639.5	9,132,172.6	120.3	1,758,137.2	103.4	
3 Нийт зардал	м.төг	44,719,862.3	52,283,502.4	47,316,813.4	2,596,951.1	105.8	(4,966,689.0)	90.5	
4 Татварын өмнөх ашиг	м.төг				-		-		
5 Цэвэр ашиг /алдагдал/	м.төг								
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	5,835,956.3	6,998,387.7	6,708,823.2	872,866.9	115.0	(289,564.5)	95.9
	в/ НДШ	м.төг	3,472,189.6	3,834,096.1	4,022,773.8	550,584.2	115.9	188,677.7	104.9
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	2,363,178.5	3,162,741.6	2,685,322.9	322,144.4	113.6	(477,418.7)	
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	-	-	-	-		-	
э/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	588.2	1,550.0	726.5	138.3	123.5	(823.5)	46.9	
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг							
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	786.0	809.0	843.0	57.0	107.3	34.0	104.2
9	Нийт цалингийн сан	м.төг	28,175,521.4	32,101,437.4	31,627,416.7	3,451,895.3	112.3	(474,020.7)	98.5
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	2,987.2	3,306.7	3,126.5	139.2	104.7	(180.2)	94.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг							
12	Хөрөнгө оруулалт	м.төг	2,187,561.4	2,263,792.2	2,236,811.2	49,249.8	102.3	(26,981.0)	98.8
13	Нийт авлага	м.төг	7,403,905.7	-	7,648,977.2	245,071.5	103.3	7,648,977.2	
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-		-	
14	Нийт өглөг	м.төг	13,102,013.6	-	10,971,265.2	(2,130,748.4)	83.7	10,971,265.2	
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	13,102,013.6	-	10,971,265.2	(2,130,748.4)	83.7	10,971,265.2	
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-		-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Боловсролын их сургууль эрхэм зорилгоо “Өөрчлөгдөн хөгжигч багш болон үндэсний хэмжээнд тэргүүлэх мэргэжилтэн бэлтгэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих”, алсын хараагаа “багш боловсролоор бүс нутагтаа өрсөлдөхүйц их сургууль болох дээд боловсролын байгууллага байна” гэж тодорхойлсон.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тодорхойлсон байна. Үүнд:

- Боловсролын үйлчилгээний чанарыг орчин үеийн их сургуулийн түвшинд хүргэж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Боловсролын болон бусад салбарын мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, зэрэг ахиулж мэргэшүүлэх;
- Эрдэм шинжилгээ, инновацын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, судалгааны үнэ цэнэ, нийгэмд үзүүлэх нөлөөг дээшлүүлэх.

Тус сургуулийн дүрэмд зааснаар өмчийг 100 хувь төр эзэмшиж байгаа бөгөөд төрийн өмчийн төлөөллийг Засгийн газраас эрх олгосноор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлэхээр заасан байна.

Тус сургууль нь Засгийн газрын тэтгэлэг болон сургуулийн нийт 8 тэтгэлгийг жил бүр элсэгчдэдээ олгодог байна. Мөн оюутанд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ судалгаа, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулж, 216,625 номын сан хөмрөг бүхий 5 салбар номын сан, 2950 оюутны багтаамж бүхий 11 оюутны дотуур байртайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд багш удирдлагууд дараах дотоод болон гадаадын төслүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Шинжлэх ухаан технологийн сангийн “Графын топологи индексүүд”, “Их богд уулын байгалийн цогцолборт газрын ландшафтын хувирал, өөрчлөлтийн тандан судалгаа”, “Дорнод Монголын неолитын үеийн аж ахуйн үйлдвэрлэлийн түүхийн судалгаа” төслүүдийг 65.7 сая төгрөгөөр;
- Канадын их сургуулийн “Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх малчдын ойлголт төсөөллийн жендерийн дүн шинжилгээ” төслийг 38.8 сая төгрөгөөр;
- Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангаас 230.4 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, “Алслагдсан орон нутгийн багш сурагчдын англи хэлний ур чадварыг дэмжих”, “Цэцэрлэгийн хүүхдийн хамгааллын бодлого”-ын төслүүдийг тус тус хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Боловсролын их сургуулийг 1951 оны Сайд нарын зөвлөлийн 178 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Сургуулийн удирдлагыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар,

хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж заасны дагуу Боловсролын сайд томилж байна.

Тус сургууль нь үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд сургуулийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласан;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн баталсан;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлах тухай тушаал;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Чанарын баталгаажуулалт мониторингийн алба 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр байгуулагдаж, 2025 онд 5 зорилгын хүрээнд 27 ажил гүйцэтгэснээс хэрэгжилт 96.3 хувьтай гэж тайлагнасан байна. Мөн Архивын ерөнхий газраас улсын үзлэг явуулж, 85.5 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн. БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт

Монгол Улсын Боловсролын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,993.2 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	27,091,175.1	31,615,328.7	4,524,153.6
Авлага	7,403,905.8	7,648,977.2	245,071.4
Бараа материал	388,315.3	227,499.1	(160,816.2)
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	29,279.5	87,927.4	58,647.9
Үндсэн хөрөнгө	64,259,771.6	62,585,904.6	(1,673,867.0)
Нийт хөрөнгө	99,172,447.3	102,165,637.0	2,993,189.7
Өр төлбөр	13,102,013.5	10,971,265.2	(2,130,748.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	86,070,433.8	91,194,371.8	5,123,938.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	99,172,447.3	102,165,637.0	2,993,189.7

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь 4,524.2 сая төгрөгөөр өссөн нь банкны хүүгийн орлоготой холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 245.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд оюутны сургалтын авлага 257.6 сая төгрөгөөр бүртгэсэн нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 227.5 сая төгрөг болж, өмнөх оноос 160.8 сая төгрөгөөр буурсан нь Ректорын 2025 оны 192 дугаар тушаалаар 145.2 сая төгрөгийн бараа материал акталснаас шалтгаалсан.

Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл 87.9 сая төгрөг болж, өмнөх оноос 58.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь томилолтын урьдчилгаа, хөрөнгийн урьдчилгааг 87.9 сая төгрөгөөр тус тус бүртгэсэн нөлөөлсөн байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 62,585.9 сая төгрөг болж, 1,673.9 мянган төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Тайланд онд өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 2,182.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, Боловсролын ерөнхий газраас 46.7 сая төгрөгийн компьютер, ширээ сандал, Хамтын ажиллагааны хүрээнд Өвөр Монголын их сургуулиас 0.8 сая төгрөгийн ном сурах бичиг, Боловсролын яамнаас 6.5 сая төгрөгийн зөөврийн компьютер, Азийн хөгжлийн банкнаас 12.5 сая төгрөгийн ширээ сандал, зөөврийн компьютер, Эрасмус төслөөс 129.1 сая төгрөгийн компьютер, Баян Өлгий Багшийн сургуульд 2.5 сая төгрөгийн ном, Америкийн Ideawald төрийн бус байгууллагын төслөөс 10.8 сая төгрөгийн дрон, камер, ухаалаг дэлгэц, нийт 208.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 343 дугаар тогтоолоор 1,638.1 сая төгрөгийн 915 нэр төрлийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан, 3,833.6 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,971.3 сая төгрөг болж 2,130.7 сая төгрөгөөр буурсан нь урьдчилж орсон орлогоос 1,887.9 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн, байгууллагад төлөх өглөг 243.5 сая төгрөгөөр буурсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 5,123.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 5,605.3 сая төгрөг болон өмнөх үеийн үр дүнг 479.8 сая төгрөгөөр бууруулж нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн залруулга хийсэн нь нөлөөлжээ. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт залруулгаар байгууллагад өгөх өглөг 131.5 сая төгрөгийг олгосон, найдваргүй авлагын 626.9 сая төгрөгийг Удирдах зөвлөлийн тогтоолоор хассантай холбоотой байна.

3.5 Эдийн засгийн зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу сургуулийн захирал нь байгууллагын орлого, зарлагын төсөв, худалдан авах төлөвлөгөөг боловсруулан Монгол Улсын Боловсролын их сургуулийн удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.5.1 Эдийн засгийн зорилтод түвшний төлөвлөлт

Удирдах зөвлөлийн 2024 оны 18 дугаар тогтоолоор тайлант оны нийт зардал, санхүүжилтийн эх үүсвэрийг 52,283.5 сая төгрөгөөр тооцож, үйл ажиллагааны орлогоос 49,720.4 сая төгрөг бүрдүүлж, дутагдсан эх үүсвэрийн 2,563.0 сая төгрөгийг өмнөх оны мөнгөн хөрөнгийн шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 870.0 сая төгрөг зарцуулахаар баталсан.

3.5.2 Эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 12,753.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 35,441.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 351.7 сая төгрөг, бусад орлого 5,495.3 сая төгрөг нийт 54,041.6 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 47,316.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 2,236.8 сая төгрөг, нийт 49,553.6 сая төгрөг зарцуулсан байна.

Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг удирдах зөвлөлийн 2024 оны 18 тогтоолоор Худалдан авах төлөвлөгөөг 2,263.8 сая төгрөгөөр, Монгол Улсын боловсролын их сургуулийн захирал 2,462.9 сая төгрөгөөр зөрүүтэй дүнгээр баталсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг өөрийн хөрөнгөөр барилга байгууламж 472.1 сая төгрөг, тоног төхөөрөмж 1,429.0 сая төгрөг, тавилга 494.8 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 66.9 сая төгрөг нийт 2,462.9 сая төгрөгийн 234 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр 13 бүрэлдэхүүн сургууль харьяа нэгжээр тулган баталгаажуулахад 204 ажилд 1,929.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 97.6 сая төгрөгийн 20 ажлын нэр төрлийг өөрчлөн худалдан авалт хийсэн.

**Монгол Улсын Боловсролын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан**

/мянган төгрөгөөр/

№	ХАА-ны байршил	Төлөвлөлт		Хэрэгжилт			Хэрэгжээгүй		Нэр төрөл өөрчилсөн	
		төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	санхүүжилт олгосон	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо
1	Хөгжлийн данс	110,668.0	-	-	-	-	110,668.0	-	-	-
2	Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль	243,500.0	15	218,125.0	213,662.6	13	-	0	25,375.0	2
3	Захиргаа аж ахуй	467,301.2	37	387,480.4	317,813.5	23	37,000.0	2	42,820.8	12
4	Боловсрол судлалын сургууль	200,000.1	29	117,900.0	176,376.6	23	82,100.1	6	-	-
5	Биеийн тамирын сургууль	188,450.0	13	68,450.0	68,450.0	11	120,000.0	2	-	-
6	Математик байгалийн ухааны сургууль	219,999.9	62	219,999.9	219,999.9	62	-	-	-	-
7	Дүрслэх урлаг технологийн сургууль	171,005.0	14	147,605.0	140,893.8	11	-	-	23,400.0	3
8	Ерөнхий боловсролын сургууль	140,608.0	14	140,608.0	137,299.0	14	-	-	-	-
9	Сургуулийн өмнөх боловсролын сургууль	106,200.0	7	106,200.0	102,405.0	7	-	-	-	-
10	Багшийн сургууль	325,000.0	12	325,000.0	287,896.7	12	-	-	-	-
11	Архангай багшийн сургууль	51,355.0	17	51,355.0	49,427.1	17	-	-	-	-
12	Оюутны байр	230,289.2	10	230,289.2	211,907.5	10	-	-	-	-
13	БаянӨлгий багшийн сургууль	8,500.0	4	2,500.0	3,677.8	1	-	-	6,000.0	3
	Нийт дүн	2,462,876.4	234	2,015,512.5	1,929,809.5	204	349,768.1	10	97,595.8	20

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Боловсролын их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Монгол Улсын Боловсролын их сургууль, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн ахлах аудитор О.Чулуунбаатар, аудитор П.Энхбаяр, аудиторын туслах Ц.Цэнгэлмаа, хуульч С.Эрдэнэ Ус нар гүйцэтгэж, захирал О.Бурмаа анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Батхишиг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Боловсролын их сургууль 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтод түвшний гүйцэтгэлийн тайлангаа “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-д 2026 оны 2 дугаар сарын 11-ний өдөр 01/161 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 46,836.4 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 468.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 175.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн системд 13 нэгжийн ил тод байршуулбал зохих 2267 мэдээллээс 58 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.2 “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.1.3 “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.4 “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5 “аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд дараах зөрчил илэрлээ.

1. Илрүүлэлт Улсын бүртгэлийн гэрчилгээнд 1,089.7 сая төгрөгийн эздийн өмчийн өөрчлөлтийг нэмж бүртгүүлээгүй байна.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээнд цаг тухайд нь бүртгүүлж байх зөвлөмж өгөв.

2. Илрүүлэлт: Тус сургуулийн удирдах зөвлөл нь 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дүрслэх урлаг технологийн сургууль, сургуулийн өмнөх боловсролын сургуульд компьютерын лаборатори нийлүүлэх ажлыг 175.0 сая төгрөгөөр тусгасан боловч батлагдсан төлөвлөгөөг баримталж ажиллагаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж тус тус заасантай нийцэхгүй байна байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бараа, ажил үйлчилгээний нэр төрлөөр нь нарийвчлан төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Монгол Улсын Боловсролын их сургуулийн 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтод түвшний гүйцэтгэлийг завсрын аудитад хамруулж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч, эрсдэлийг

тодорхойлж аудитын ерөнхий стратегийг боловсруулж, төлөвлөсөн горим, сорил хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Боловсролын их сургуулийн хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 2,188.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, 26.9 сая төгрөгийн 3 алдааг залруулах, 2,161.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 6 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн. Шилэн дансны албан шаардлага хэрэгжээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 256.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3 төлбөрийн акт, 3 албан шаардлага өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 100.0 хувийн биелэлттэй байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	3	6,674.9	3	6,674.9	100.0
Албан шаардлага	2	226,725.3	2	226,725.3	100.0
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	23,487.1	1	23,487.1	100.0
Дүн	6	256,887.3	6	256,887.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Удирдлагын тушаал, шийдвэрийн хэрэгжилт, тэдгээрийн үр нөлөө, зарцуулалтын үндэслэл, тайлагналын үнэн зөв байдал, ил тод байдал, түүнчлэн холбогдох журам, гэрээний хэрэгжилт, биелэлтийг хамруулан шалгах шаардлагатай гэж үзэж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 31.9 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- М банкны дансны үлдэгдлийн баталгааг гүйлгээ баланстай тулгахад 13.9 сая төгрөгөөр зөрүүтэй баталгаажуулсан;
- Гүйлгээ балансыг мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн баталгаатай тулгахад 18.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 12.7 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 8.8 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, 3.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 12.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 468.4 сая төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын багшийн их сургуульд 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 5-ны өдрийн хооронд сургалтад хамрагдсан албан хаагчийн томилолтын зардал 2.9 сая төгрөгийн төсвөөс өмнөх онд 1.1 сая төгрөгийг олгож, тайлант онд 1.8 сая төгрөгийг өглөг үүсгэлгүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2.Илрүүлэлт:Тус сургууль нь нийтлэг үйлчилгээний албан хаагчдын дунд зохион байгуулагдсан тэмцээний зардалд 7.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.8 байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, төсвийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт: Татварын И-баримт цахим системд 3.9 сая төгрөгийн төлбөрийн баримт дутуу бүртгэж, гүйлгээ хийж баталгаажуулсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын И-баримт цахим системд төлбөрийн баримтыг бүрэн бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	М банкны дансны үлдэгдлийн баталгааг гүйлгээ баланстай тулгахад 13,939.7 мянган төгрөгөөр зөрүүтэй баталгаажуулсан байна.	1	13,939.7					1	13,939.7	-	-	-	-
2	Гүйлгээ балансыг мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн баталгаатай тулгахад 18,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	18,000.0	-	-	-	-	1	18,000.0	-	-	-	-
	Дүн	2	31,939.7	-	-	-	-	2	31,939.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийтлэг үйлчилгээний ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулагдсан тэмцээний зардалд 7,000.0 мянган төгрөгийг зарцуулж, төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	7,000.0	-	-	1	7,000.0	-	-
БНХАУ-ын Өвөр Монголын багшийн их сургуульд 2024 онд сургалтад хамрагдсан албан хаагчийн томилолтын зардал 1,820.8 мянган төгрөгийг өглөг үүсгэлгүй олгосон байна.	1	1,820.8	-	-	1	1,820.8	-	-
Татварын И-баримт цахим системд 3,900.0 мянган төгрөгийн төлбөрийн баримт дутуу бүртгэж, гүйлгээ хийж баталгаажуулсан байна.	1	3,900.0	-	-	-	-	1	3,900.0
Дүн	3	12,720.8			2	8,820.8		3,900.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд 13 нэгжийн ил тод байршуулбал зохих 2267 мэдээллээс 58 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Улсын бүртгэлийн гэрчилгээнд 1,089,729.3 мянган төгрөгийн өөрчлөлтийг нэмж бүртгүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Тус сургуулийн удирдах зөвлөл нь 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд сургуульд компьютерын лаборатори нийлүүлэх ажлыг 175,000.0 мянган төгрөгөөр тусгасан боловч батлагдсан төлөвлөгөөг баримталж ажиллагаагүй байна.	1	175,000.0	-	-	-	-	1	175,000.0
Дүн	3	175,000.0	-	-	1	-	2	175,000.0
Нийт дүн	3	175,000.0	-	-	1	-	2	175,000.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 599/A0150458

Улаанбаатар хот

САГ - 2026/45/НА - СТА - ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын багшийн их сургуульд 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 5-ны өдрийн хооронд сургалтад хамрагдсан албан хаагчийн томилолтын зардал 2,895,600.00 /хоёр сая найман зуун ерэн таван мянга зургаан зуун/ төгрөгийн төсвөөс өмнөх онд 1,074,800.00 /нэг сая далан дөрвөн мянга найман зуун/ төгрөгийг олгож, тайлант онд 1,820,800.00 /нэг сая найман зуун хорин мянга найман зуун/ төгрөгийг өглөг үүсгэлгүй олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1 “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн захирал /Ж.Батбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Уранжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯАН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 598/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/45/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургууль нь нийтлэг үйлчилгээний албан хаагчдын дунд зохион байгуулагдсан тэмцээний зардалд 7,000,000.00 / долоон сая/ төгрөг зарцуулсан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.8. байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, төсвийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн захирал /Ж.Батбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Уранжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 597/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/45/НА - СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн системд 13 нэгжийн ил тод байршуулбал зохих 2267 мэдээллээс 58 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.1 "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.2 "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.3 "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.1.4 "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.5 "аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн захирал /Ж.Батбаатар/, ерөнхий нягтлан бодогч /М.Уранжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯАН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
О.БУРМАА

